



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлд:

2. ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд овоолгуудын одоогийн ашиглалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай танилцуулах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эзэмшиж байгаа овоолготой холбоотой “Эрдэнэт уулын өгөөж” ХХК-иас ирүүлсэн “Катодын зэсийн үйлдвэр байгуулах төсөл”-ийг “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн шүүхийн маргаантай асуудал эцэслэн шийдэгдсэний дараа нэгтгэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уусган баяжуулах аргаар исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрээс цэвэр зэс үйлдвэрлэх “Катодын зэсийн үйлдвэр байгуулах төсөл”-ийг жишиг загвар болгон хэрэгжүүлэх, “Эрдмин” ХХК-ийн хувьцааны 25 хувийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ эзэмшиж байгааг 34 хувь болгон нэмэгдүүлэх, “Ачит Ихт” ХХК-тай одоогийн ашиглаж буй овоолгын ашиглалтын болон тус компанийн 34 хувийн эзэмшлийг сэргээх талаар хэлцэл хийж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эрх ашигт нийцсэн тохиролцоонд хүрсэн тохиолдолд “Хамтын ажиллагааны гэрээ”-г шинэчлэн байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

